



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ЕРӨӨ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМД**

2024.08.05 № ГНАГ-2024/13-МТА-НА-05  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020501

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


### Дүгнэлт

Монгол Ардын намын Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ерөө сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Ерөө сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ЕРӨӨ СУМЫН МАН-ЫН ХОРООНООС  
ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ЕРӨӨ СУМ**

**2024 ОН**



**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд Ерөө сумын МАН-ын хорооноос дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр**

2024.06.24

100 жилийн түүхтэй Ерөө сум маань бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хот хөдөөгийн шинэ сэргэлтийн бодлогыг алсын хараатайгаар хэрэгжүүлэх зорилтын хүрээнд "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-гөө боловсруулж дэд бүтэц, нийгэм соёлын томоохон бүтээн байгуулалтуудыг хийсээр байна. Бид дээрх бий болгосон бааз дээрээ суурилан Ерөө нутгийнхаа хөгжлийг илүү хурдацтай шинэ шатанд гаргах зорилгоор иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн саналд тулгуурлан 2024-2028 онд Монгол Ардын Намаас хэрэгжүүлэх Мөрийн хөтөлбөр болгон дэвшүүлэн тавьж байна. Энэхүү хөтөлбөр маань хэрэгжсэнээр иргэд илүү ая тухтай, аюулгүй орчинд жаргалтай амьдарч хөгжих боломж бүрдэж сум маань аймаг, бүс нутагтаа төдийгүй улсдаа тэргүүлэх сум болно гэдэгт бүрнээ итгэлтэйгээр дэвшүүлсэн зорилтууд бүхий мөрийн хөтөлбөрөө танилцуулж байгааг хүлээн авна уу.

**УРИАЛГА : САЙХАН ОРЧИН, ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ**

**Нэг. НИЙГМИЙН БОДЛОГО**

**Нэг. БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД**

- 1.1.1 Хүн амын хэтийн төлөв, шилжилт хөдөлгөөн, хүүхдийн ердийн өсөлтийг харгалзан бодит хэрэгцээнд тулгуурлан 150 хүүхдийн дотуур байрыг шинээр барьж ашиглалтад оруулах асуудлыг зохих шатанд уламжилж шийдвэрлүүлнэ.
- 1.1.2 Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор тодорхой мэргэжлийн мэргэшсэн багшийг урьж сургалт зохион байгуулна.
- 1.1.3 Эдүтэн, Персон хөтөлбөр хэрэгжиж буй цахим сургалтын танхимын шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчилж, цахим ангийг зориулалтын ширээ сандлаар хангах асуудлыг бодлогоор дэмжиж холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.
- 1.1.4 Мэдээлэл технологийн ангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор дотуур байр, сургуулийн гадаад, дотоод орчинд хяналтын камер суурилуулах ажлыг хамтран зохион байгуулна.
- 1.1.6 Сургуулийн дэргэдэх архивын өрөөг зориулалтын архивын шүүгээтэй болгох асуудлыг дэмжиж ажиллана.

- 1.1.7 Бугант тосгонд 640 хүүхдийн суудалтай шинэ сургуулийг барьж ашиглалтад оруулах асуудлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.1.8 Сум, багийн төвөөс алслагдсан хэсгийн хүүхэд багачуудыг сурч боловсрох нөхцөлөөр ханган хүүхэд тээвэрлэх машинтай болох асуудлыг хувийн хэвшил болон төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 1.1.9 Анги танхимуудад стандартын шаардлага хангасан ухаалаг дэлгэц, телевизтэй болох асуудлыг дэмжиж ажиллана.
- 1.1.10 Байгалийн ухааны хичээлийн туршилт хийх лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй болох асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 1.1.11 Багш, сурагчдыг гадаадад солилцоогоор ажиллуулж мэдлэг, чадварыг дээшлүүлж, туршлага судлуулна.
- 1.1.12 Орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг бодлогоор үргэлжлүүлэн дэмжиж төр, төсвийн байгууллагуудыг мэргэшсэн сайн боловсон хүчнээр ханган, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.1.13 Бугант тосгонд 75 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг барих ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.1.14 Стандартын шаардлага хангасан гадаа тоглоомын талбай барьж байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.1.15 Боловсролын чиглэлээр 2020-2024 онуудад хийж хэрэгжүүлсэн зохих ажил, арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллана.
- 1.1.16 Боловсролын салбарт чанарын менежментийн тогтолцооны зөвлөх үйлчилгээ авч, олон улсын стандарт хэрэгжүүлэгч байгууллага болгоно.
- 1.1.17 Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж хүүхдийг өөрийн авьяас чадварт нь тулгуурлан хөгжүүлж амьдралын зөв дадалд сургана.
- 1.1.18 Бага, дунд боловсролын сургалтын чанарт жил бүр хөндлөнгийн хяналт хийж эцэг эхчүүдэд танилцуулж үнэлүүлдэг болно.

## **1.2. Эрүүл мэндийн хүрээнд**

- 1.2.1 А зэрэглэлтэй сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын асуудал шийдвэрлэгдсэнтэй холбогдуулан тойргийн сумдын хүн амд 4 төрлийн /дотор, хүүхэд, төрөх, мэс засал/ тусламж үйлчилгээг үзүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.2 Хүүхэд, нялхсыг товлолын дагуу дархлаажуулалтад бүрэн хамруулж, вируст гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулсан байна.
- 1.2.3 Иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамруулж ажиллана.
- 1.2.4 Эрсдэлт зан үйлийг бууруулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг хийж, уг арга хэмжээнд байгууллага, олон нийт, сайн дурын идэвхтэнг татан оролцуулж ажиллана.

- 1.2.5 Боловсролын салбарын багш нарт зориулсан эрүүл мэндийн хичээл, цахим контент, бусад хэлбэрээр эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг сайжруулна.
- 1.2.6 Нийгмийн эрүүл мэндийг дэмжихэд салбар дундын болон олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтарч ажиллана.
- 1.2.7 Сумын хэмжээнд хүнсний эрүүл ахуйчийн орон тоог нэмэгдүүлж орон нутагт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газруудын хүнсний аюулгүй байдалд анхаарч ажиллана.
- 1.2.8 Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ /дотор, эмэгтэйчүүд, хүүхэд, мэс засал, шүд/ үзүүлэхтэй холбоотойгоор боловсон хүчний асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.2.9 Нарийн мэргэжлийн эмчээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад орон нутгийн төсвөөс олгох урамшууллын бодлогыг хэрэгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.10 Эрүүл мэндийн төвийн ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулж урамшуулан дэмжиж ажиллана. /төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах гэх мэт/
- 1.2.11 “Цахим эрүүл мэнд” шилжилттэй холбоотойгоор Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, цахим үйлчилгээг нэвтрүүлэн ажиллана.
- 1.2.12 Өндөр хүчин чадалтай биохимийн аппараттай болох, нян өсгөвөрлөх /бактериологи/ шинжилгээг хийх боломжийг бүрдүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.2.13 Тусламж үйлчилгээнд зориулж бүрэн тоноглогдсон автомашины асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 1.2.14 Ахмадын болон хүүхдийн сувиллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор шинээр барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилна.
- 1.2.15 Ерөө сум, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийг үе шаттайгаар шийдвэрлэж, ашиглалтад оруулна.

### **1.3. Спорт, соёл урлагийн хүрээнд**

- 1.3.1 Сумандаа 400 хүний суудалтай шинэ Соёлын төв барих ажлыг орон нутгийн хэмжээнд хяналт тавьж байнгын ашиглалтад хүлээж авна.
- 1.3.2 Сумын номын сангийн уншлагын танхимыг интернэтэд холбож компьютер, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.3.3 Сумын орон нутаг судлах музейн үзмэрийг баяжуулж, орон нутгийнхаа онцлог, түүх соёлыг сурталчилна.
- 1.3.4 Сум, тосгоны хэмжээнд өсвөр үе, залуучууд, иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэн эрүүлжих фитнес төвийг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр шат дараатай хангана.
- 1.3.5 Сумандаа өвлийн спортыг хөгжүүлэх зорилгоор “Хоккей”-н талбайг шинээр барьж байгуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

- 1.3.6 Хүн амын удмын сан, генийг авч үлдэх, цус ойртохоос урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөллийн ажил өрнүүлж, угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлнэ.
- 1.3.7 Дугуйн болон явган аяллыг дэмжиж сумын төвийн авто замын дагуу дугуйн болон явган хүний замыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

#### **1.4. Хүн ам, нийгмийн бүлэг рүү чиглэсэн бодлогын хүрээнд**

- 1.4.1 Хүүхэд гэр бүлд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 1.4.2 Гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох арга хэмжээг зохион байгуулж Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусгаж ажиллана.
- 1.4.3 Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж олон талт арга хэмжээг зохион байгуулан, эрсдэлийг тодорхой түвшинд бууруулж ажиллана.
- 1.4.4 Ахмад настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах зорилгоор жил бүрийн төсөвт тодорхой зардлыг тусгаж ажиллана.
- 1.4.5 Хүүхэд, Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана.

#### **Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:**


- 2.1.1 Бугант тосгоныг сумын төвтэй хатуу хучилттай замаар холбох ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 2.1.2 Малаа эрчимжүүлэх зорилгоор төвлөрсөн айл өрхүүдийг цахилгаан, эрчим хүчээр хангах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.
- 2.1.3 Ойн мэргэжлийн байгууллагуудыг түшиглэн мод боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн гаргах үйлдвэр барих, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн дэмжиж ажиллана.
- 2.1.4 Шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг улс, орон нутгийн төсөвт суулган ашиглалтад оруулах ажлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 2.1.5 Сум, тосгоны төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь замуудыг хатуу хучилттай болон хайрган замыг үе шаттайгаар барьж, хүчитгэл, нөхөлт хийж, стандартын шаардлага хангасан замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлнэ.
- 2.1.6 Гудамж талбайн гэрэлтүүлгийг засварлан, тодорхой хэсгүүдэд нэмж гэрэлтүүлэг тавих асуудлыг дэс дараатай хийж гүйцэтгэнэ.
- 2.1.7 Инженерийн байгууламж, шугам сүлжээнд аж ахуйн нэгж, байгууллагууд болон айл өрхүүдийг холбох ажлын санхүүжилтийг холбогдох шатанд уламжлан, шийдвэрлүүлэн барилгын ажлыг эхлүүлж ажиллана.
- 2.1.8 Сумын төвийн урд жижиг гүүрнээс Гэрэлт хайлааст /тасаг/ хүртэлх 3 км хайрган хучилттай замыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хийж гүйцэтгэнэ.
- 2.1.9 Сумын хэмжээнд стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг шинээр барьж байгуулах ажлыг нэмэгдүүлнэ.

- 2.1.10 Ерөө сумын төв болон Бугант 3-р багийн тодорхой хэсгүүдэд үерийн далан, ус зайлуулах сувгийг байгуулах ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 2.1.11 Аж үйлдвэр байгуулах чиглэлээр санал санаачилга гаргасан аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллана.

### **Гурав. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО:**

#### **3.1 Хөдөө аж ахуй**

- 3.1.1 Мал үржлийн төвийн үйл ажиллагааг тогтвортой болгож нэг малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- 3.1.2 Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангаж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 3.1.3 “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийн хүрээнд хоршоодын үйл ажиллагааг дэмжиж, төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн мал аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 3.1.4 Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын үйлдвэрлэлээ өргөтгөх, хорших, ажлын байраа хадгалах, зээл төсөл хөтөлбөрт хамрагдах санаачилгыг дэмжиж ажиллана.
- 3.1.5 Алслагдсан бэлчээрийг ашиглах, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргаж, зам давааг засаж сайжруулна.
- 3.1.6 Малын ашиг шимийг сайжруулах зорилгоор малд үзлэг ангилалт, хувьсан ангилалт хийж үүлдэр угсаа, чанарыг сайжруулна.
- 3.1.7 Ерөө үүлдрийн нарийн нарийвтар ноост хонийг өсгөн үржүүлэх, тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор үр шилжүүлэн суулгах ажлыг үргэлжлүүлэн дэмжинэ.
- 3.1.8 Мах, сүүний жишиг үхрийн аж ахуйн фермертэй болох асуудлыг төрийн байгууллага болон төсөл хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлнэ.
- 3.1.9 Малын эрүүл мэндийг хамгаалах Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.1.10 Тариалангийн талбайг бүрэн хашаажуулж, бүртгэлжүүлэх, газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.1.11 Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх, газар эзэмшигчийн үүрэг хариуцлагыг сайжруулна.
- 3.1.12 Үржил шим бүхий хөрсөнд тариалсан монгол таримлын өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор бүсийн үр үржүүлэх, ариутгах газартай болох ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлнэ.
- 3.1.13 Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн тогтвортой ажиллах мэдлэгээ дээшлүүлэх нөхцөлийг сайжруулж, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэн залгамж халааг бэлтгэнэ.
- 3.1.14 Шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.15 Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянаана.





- 3.1.16 Бугант тосгонд стандартын шаардлага хангасан өвлийн хүлэмж болон зoorь барих асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

### **3.2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ**

- 3.2.1 Худалдааны төвийг суманд байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно.
- 3.2.2 Сумын өрхийн үйлдвэрлэлийг сумын тэргүүлэх чиглэлийн дагуу нэмэгдүүлэн зээл, төсөл, хөтөлбөрт хамруулна.
- 3.2.3 Орон нутгийн иргэдийн бие даасан бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлнэ.
- 3.2.4 Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.5 Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.
- 3.2.6 Зээлийн батлан даалтын санг сурталчлах, үйл ажиллагааг нь өргөжүүлж сайжруулна.
- 3.2.7 Органик, баяжуулсан, зохицуулах үйлчлэлтэй, инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, ногоо даршлах бага оврын цех байгуулж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжиж ажиллана.
- 3.2.8 Стандартын шаардлагад нийцсэн мал нядалгааны төв, мах, сүү, арьс шир боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшил, төрийн дэмжлэгтэйгээр байгуулна.
- 3.2.9 Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх “Баялаг бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа”-г бүсийн хэмжээнд зохион байгуулна.
- 3.2.10 Жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн эрхлэгчдийн бүтээмжийг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж чанар, стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.
- 3.2.11 Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулж, түүхий эд нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг бий болгоно.
- 3.2.12 Жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож байгаа төрийн болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилтийг үр ашигтай болгож, оролцогч талуудын уялдааг сайжруулна.

### **Дөрөв. ЗАСАГЛАЛ, НУТГИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО**

- 4.1.1 Төрийн цахим үйлчилгээний хэрэглээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж Киоск машины үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 4.1.2 Сумандаа нотариатын үйлчилгээг тогтмолжуулна.
- 4.1.3 Газрын харилцааны үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор үйлчилгээний Киоск машиныг хэрэглээнд нэвтрүүлнэ.
- 4.1.4 Байгууллагын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн шаардлагатай программ хангамжийг нэвтрүүлэн мэдээлэл хадгалах, дамжуулах тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг дэмжиж ажиллана.

- 4.1.5 ЗДТГ-ын байрыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулах асуудлыг холбогдох шатанд уламжилна.
- 4.1.6 “Таныг сонсьё” арга хэмжээг улирал тутамд зохион байгуулж төрийн үйлчилгээг сумын төвөөс алслагдсан хэсэгт шуурхай хүргэж ажиллана.
- 4.1.7 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад хамруулж, ур чадварыг нь дээшлүүлнэ.
- 4.1.8 Бүсийн төрийн албан хаагчдын туршлага солилцох уулзалтыг жил бүр зохион байгуулна.
- 4.1.9 Хэрэглэгчийн санал асуулгыг улирал тутамд зохион байгуулж үр дүнг үнэлэн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 4.1.10 Чанарын менежментийн тогтолцооны стандартын хэрэгжилтийг хангаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулан олон улсын стандарт хэрэгжүүлэгч байгууллага болно.

### **Тав. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 5.1.1 Уул уурхай, үйлдвэрлэлийн улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох, хяналт шалгалтыг эрчимжүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ.
- 5.1.2 Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.1.3 Үүсэх хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэртэй болох, санал санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллана.
- 5.1.4 Ойжуулах ойн сургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 5.1.5 Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх булаг шандын эхийг хамгаалах, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
- 5.1.6 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ.
- 5.1.7 Тэрбум мод үндэсний хөдөлгөөн “Өрх бүр 5 мод” хөдөлгөөнийг эрчимтэй зохион байгуулж ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлж шинээр цэцэрлэгт хүрээлэнг бий болгоно.
- 5.1.8 Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулж, дүгнэж ажиллана.
- 5.1.9 Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.1.10 Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий самбар, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байршуулж, хэвлэл мэдээлэл, цахим хэрэгслээр байгаль орчны хууль тогтоомж, байгаль

хамгаалах уламжлалт ёс заншлыг сурталчлан таниулах, мэдээллийг түгээх ажлыг тогтмолжуулж, уг үйлсэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- 5.1.11 Ойн мэргэжлийн байгууллагуудын менежмент төлөвлөгөөний дагуу жил бүр улсын болон өөрийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг чанартай сайн гүйцэтгүүлэх, мод үржүүлгийг нэмэгдүүлж түүнээс гарсан бүтээгдэхүүнийг нийлүүлэх ажлыг дэмжиж ажиллана.
- 5.1.12 Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг нэмэгдүүлэх, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, олон нийтийн газрын нүхэн жорлонг ЭКО нойл болгох, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төслийг хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.
- 5.1.13 Иргэдийн санал санаачилгын хүрээнд бичил уурхайн асуудлыг зохих шатанд уламжилж шийдвэрлүүлнэ.

--oOo--